



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/76

Модот

Малжуулах арга хэмжээнд хамруулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хэнтий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн “Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгийг сонгон шалгаруулах” ажлын удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны “Малчдыг малжуулах” арга хэмжээнд сумын малчин өрх, иргэн Баянжаргалын Баяржавхланыг хамруулсугай.

Мал хүлээлцэх ажлын хэсэгт:

Ажлын хэсгийн дарга: Э.Энхмандах – Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга У.Гантулга – Хужхан багийн Засаг дарга  
Гишүүд Я.Отгонтуяа – Газрын даамал

2. “Малчдыг малжуулах” арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Э.Энхмандах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



